



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 396

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний геологийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 15,300,000.00 (арван таван сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Үндэсний геологийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай;

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001898

19-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
396 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ХИЛ
ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА "ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Улсын дугаар	Арлын дугаар	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ /хуримдлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
1	Үндэсний геологийн алба	Тоёота Ланд крузер- 76 маркийн суудлын автомашин	2011-04-26	42-37 УНМ	JTEEB71J0 07012491	1	ш	15,300,000.00	2	1,500,000.00
						1		15,300,000.00		1,500,000.00
								(арван таван сая гурван зуун мянга) төгрөг		(нэг сая таван зуун мянга) төгрөг

Нийт дүн